

Сортын бүтээгчийн эрх олгох, нийтэд мэдээлэх тухай журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэ журмын зорилго нь таримал ургамлын шинэ сортын бүтээгчид бүтээгчийн эрх олгох, түүнийг нийтэд мэдээлэхтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Бүтээгчийн эрх олгоход тавих шаардлага

2.1. Дараахь шаардлагыг хангасан сортод бүтээгчийн эрх олгоно:

2.1.1. Шинэ сортын бүтээгчийн эрх авах тухай хүсэлтээ Таримал ургамлын үр, сортын тухай хуульд заасны дагуу үр, сортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргасан байх;

2.1.2. Тухайн сортыг шинэ болохыг тогтоосон байх;

2.1.3. Тухайн сортыг ялгаатай, жигдэрсэн, тогтворжсныг тогтоосон байх;

2.1.4. шинэ сортын нэр нь Таримал ургамлын шинэ сортын нэрийг бүртгэх тухай журманд заасны дагуу шүүлт хийгдэж хадгалагдсан байх;

2.1.5. сортын бүтээгчийн эрхийг хүчин төгөлдөр байлгахад шаардагдах төлбөр, хураамжийг төлсөн байх.

2.2. Энэ журмын 2.1.2-2.1.3-т заасан шаардлагыг хангасныг журманд заасны дагуу хийсэн сорт сорилтын үр дүнгээр баталгаажуулна.

Гурав. Шинэ сортын бүтээгчид тавих шаардлага

3.1. Сортын бүтээгч нь Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 4.1.8-д заасан дараахь этгээд байна:

3.1.1. сортыг бүтээсэн, эсхүл нээн илрүүлж сайжруулсан хувь хүн, хуулийн этгээд;

3.1.2. сортыг бүтээсэн этгээдийн ажил олгогч;

3.1.3. гэрээслэх, бэлэглэх, солилцох, худалдах замаар эрхийг шилжүүлэн авсан этгээд.

3.2. Сортыг сонирхогч иргэн, тариаланч, эрдэм шинжилгээний ажилтан, эрдэм шинжилгээний хүрээлэн, сорт бүтээх чиглэлээр мэргэшсэн хуулийн этгээд бүтээж болно.

3.3. Энэ журмын 3.1.2-3.1.3-т заасан этгээдийн хувьд бичгээр үйлдсэн нотлох баримтыг үндэслэн эрх бүхий болохыг тогтооно.

3.4. Шинэ сортын хэд хэдэн этгээд хамтарч бүтээсэн бол бичгээр үйлдсэн хамтран ажиллах тухай гэрээтэй байна.

Дөрөв. Шинэ сортын бүтээгчийн эрхийг олгох

4.1. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 14, 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5

хоногт багтаан тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүтээгчийн эрх олгоно.

4.2. Бүтээгчийн эрх олгохтой нэгэн зэрэг тухайн сортын нэрийг баталгаажуулна.

4.3. Бүтээгчийн эрхээр хамгаалагдсан сортыг хамгаалагдсан сортын бүртгэлд бүртгэнэ.

4.2. Шинэ сортын хэд хэдэн этгээд хамтарч бүтээсэн бол сортын бүтээгчийн эрхийг хамтран эзэмшихээр олгоно.

4.3. Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шинэ сортыг бүртгэсэн даруй цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлнэ.

4.4. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 14.11-д заасан орны эрх бүхий байгууллагад хамгаалагдсан шинэ сортын талаар түүнийг бүртгэснээс хойш ажлын 3 хоногт багтаан мэдээлнэ.

-oOo-